



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/38

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 1 хуулийн этгээд, 1 иргэний гаргасан хүсэлтийн дагуу газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын зориулалтад өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр
сарын 2.8-ны өдрийн А/... дугаар
захирамжийн хавсралт

ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ ӨӨРЧЛӨХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

№	Иргэн, хуулийн этгээдийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Эзэмшиж буй газрын зориулалт	Өөрчилж буй газрын зориулалт	Өөрчлөлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	"Хөвсгөл центр" ХХК /РД:2705079/	6712014117	1-р баг 41-1 тоот	Худалдаа, нийтийн үйлчилгээ	Аялал жуулчлал	Аймгийн Засаг даргын 2021.12.01-ний өдрийн А/576 дугаар захирамжийн хавсралтын 4 дэх заалтын 5 дахь багана	Газрын зориулалт өөрчлөх
2	Хотгойд овгийн Саранчимэг Бархасболд /РЮ95041316/	6712014303	13-р баг 4 дүгээр цэцэрлэгийн ард	5-8 давхар нийтийн орон сууц	Автомашины гараж	Аймгийн Засаг даргын 2018.11.28-ны өдрийн А/591 дүгээр захирамжийн хавсралтын 5 дахь заалтын 4 дэх багана	Газрын зориулалт өөрчлөх

-----oOo-----

Handwritten signature